НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 07 өдөр Дугаар 06 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9.8 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г хавсралтаар батлсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулахыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудад үүрэг болгосугай.

3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА Л.ЭНХ-АМГАЛАН

1119276367
5284708 СБА1473

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн
..06.. дүгээр тогтоолын хавсралт

1119276367
5284708 СБА1473

# ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Гүйцэтгэх ажлын чиглэл | д/д | Арга хэмжээ | Хариуцан хэрэгжүүлэх байгууллага | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 |
| I | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааны чиглэлээр | 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооноос үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах; | ГБХНХЯ | III-IV улирал |
| | | 2 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" сэдэвт ажил олгогчийн чуулган зохион байгуулж, тэднийг зөвлөгөө, мэдээллээр хангах; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 3 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгааны материал бэлтгэх, хэвлүүлэх, түгээх; | ХАБЭМТ | II улирал |
| | | 4 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт 1 минутын (Reel) видео контентыг олон нийтэд түгээх, мэдээллэх; | ХАБЭМТ | II улирал |
| | | 5 | Улаанбаатар хот дахь орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын удирдлага, нэгжийн удирдлагуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд удирдах ажилтнуудын манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, | ХАБЭМТ | I-II улирал |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| I | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааны чиглэлээр | | эрүүл ахуйн хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн 2 үе шаттай сургалт зохион байгуулах; | | |
| | | 6 | Улаанбаатар хот болон төвийн бүсийн 5 аймгийн хөнгөн аж үйлдвэрийн салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр зөвлөн туслах, мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах; | ХАБЭМТ | II-IV улирал |
| | | 7 | Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, холбогдох журам, дүрэм, зааврын эмхэтгэл бэлтгэх, түгээх; | НДЕГ | I-II улирал |
| | | 8 | Ажлын байрны тоосжилтын улмаас үүсэх мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх цуврал нийтлэл бэлтгэн, цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд түгээх; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 9 | Ажлын байрны тоосжилтын улмаас үүсэх мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх богино хэмжээний видео, контент бэлтгэн олон нийтэд түгээх; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 10 | Ажлын байрны тоосжилтын улмаас үүсэх мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас бэлтгэн, цахимаар сурталчилах; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 11 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг ойлголт, ач холбогдлыг таниулах чиглэлээр видео шторк, мэдээ, ярилцлага зэргийг хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд түгээн сурталчлах; | Орхон аймгийн НДГ | II улирал |
| | | 12 | Эрчим хүчний салбарын зарим ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг VR (vertual reality) контент болгон хөрвүүлэх; (салбарын хэмжээнд туршиж, ажиглалт хийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх) | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 13 | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн | НДЕГ | I-II улирал |

1119276367
5284708 СБА1473

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тухай хууль түүний ач холбогдлыг сурталчилсан маркетингийн бүтээгдэхүүн бэлтгэх, олон нийтэд түгээх; | | |
| | | 14 | Ажил олгогчдод үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотой мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II-III улирал |
| II | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын чиглэлээр | 15 | Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллагуудын холбогдох ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II улирал |
| | | 16 | Ажил олгогчдод зориулсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх цахим сургалтын модуль боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх; | ХАБЭМТ | II-IV улирал |
| | | 17 | Уул, уурхайн салбарын ажил олгогчдод Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, түүний ач холбогдол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | НДЕГ | I-II улирал |
| | | 18 | Барилгын салбарын ажил олгогчдод Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, түүний ач холбогдол, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | НДЕГ | III-IV улирал |
| | | 19 | Нийтийн аж ахуйн байгууллагуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах; (Бүсчилсэн хэлбэрээр) | ХАБЭМТ | III улирал |
| II | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид | 20 | Авто замын салбарын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн захирал, инженер техникийн ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II улирал |
| | | 21 | Газар тариалангийн салбарын ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх | ХАБЭМТ | III улирал |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын чиглэлээр | | хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах; | | |
| | | 22 | Эрүүл мэндийн салбарын удирдах албан тушаалтан, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж буй ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах; | ХАБЭМТ | I-IV улирал |
| | | 23 | Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэл өндөртэй ажлын байруудтай танилцаж, тэнд ажиллаж буй ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, аюулгүй ажиллах зан үйл төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах; (5 байгууллага) | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 24 | Хөнгөн үйлдвэрийн салбарын ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 25 | Ажил олгогчийн удирдлагуудад ажилтан, албан хаагчдыг мэргэжлээс шалтгаалсан өвчинд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн эрүүл мэндийг дэмжих Олон улсын хөдөлмөрийн байгууллагын SOLVE хөтөлбөрийн 9 модульт сургалтыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II улирал |
| | | 26 | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрсдэл өндөр ажил олгогчдод Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | Аймаг, дүүргийн НДГ | II-III улирал |
| II | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх | 27 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тариаланчдад Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар | Аймаг, дүүргийн НДГ | II улирал |

1119276367
5284708 СБА1473

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын чиглэлээр | | зөвлөгөө өгөх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; | | |
| | | 28 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн компанит ажлыг улсын хэмжээнд жилийн турш улирлын онцлогт тохируулан өрнүүлж, ажил олгогч, ажилтнуудыг мэдээллээр хангах; | ХАБЭМТ | I-IV улирал |
| | | 29 | Уламжлалт болон фермийн мал аж ахуй эрхлэгчдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын цогц аян зохион байгуулах; *(Нийгмийн даатгалд даатгуулсан 50,000 гаруй малчин даатгуулагч)* | ХАБЭМТ | II-IV улирал |
| | | 30 | Бичил уурхай эрхлэгчдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын цогц аян зохион байгуулах; *(Нийгмийн даатгалд даатгуулсан 250 даатгуулагч)* | ХАБЭМТ | II-IV улирал |
| | | 31 | Тээврийн салбарын ажилтанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын цогц аян зохион байгуулах; *(Үндэсний статистик мэдээллээр 70,000 гаруй тээвэр эрхлэгч иргэд)* | ХАБЭМТ | II-IV улирал |
| | | 32 | Хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтын дүгнэлтэд үндэслэн бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео контент бэлтгэн түгээж, зөвлөгөө, мэдээллээр хангах ; | ХАБЭМТ | II улирал |
| | | 33 | Тохижилт үйлчилгээний салбарын ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах; *(Сүхбаатар, Өмнөговь аймгуудад)* | ХАБЭМТ | II улирал |
| III | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч | 34 | “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2024” болзолт уралдааныг зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагын туршлагыг олон нийтэд сурталчлах, түгээх; | ХАБЭМТ | I-IV улирал |

1119276367
5284708 СБА1473

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчилах чиглэлээр | 35 | Дэлхийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдрийг угтан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо, төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтарсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх" уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, сошиал контент бүтээх, түгээх; | ХАБЭМТ | II улирал |
| | | 36 | Хөнгөн аж үйлдвэрийн салбарт "Нэхмэл эдлэл, гутал, хувцас, арьс шир үйлдвэрлэлийн салбарт баримтлах практик дүрэм" стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сайн туршлагыг сурталчлах богино хэмжээний нэвтрүүлэг (story telling) бэлтгэж олон нийтэд сурталчлах; | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 37 | “Оюу толгой” ХХК-ийн үйлдвэрлэлийн ослын эрсдэлийн удирдлагын тогтолцооны сайн жишээг ажил олгогчдод сурталчилах; | ХАБЭМТ | III улирал |
| | | 38 | “Мэйжор дриллинг Монголиа” ХХК-ийн хөдөлмөрийн аюулыг мэдээллэх олон улсын “TAKE-5” аргачлалыг хэрэгжүүлж буй туршлага, ололт амжилтыг ажил олгогчдод сурталчилах; | ХАБЭМТ | III улирал |
| | | 39 | Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ашиглаж буй хиймэл оюун ухаан дижитал технологийн танилцуулга зурагт хуудсыг бэлтгэх, түгээх ажлыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II улирал |
| IV | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр | 40 | Үйлдвэрлэлийн ослын улмаас шүүхээр шийдвэрлэгдсэн асуудлуудад судалгаа явуулж, дүн шинжилгээ хийж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах, тогтолцооны шинэчлэлд тусгах; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 41 | Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх “Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны тэмдэг, дохионы өнгө MNS 4643:1998 стандарт”-ыг шинэчлэн боловсруулах, хяналт-шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулах; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 42 | Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэл бүхий салбарт гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцөлд судалгаа хийж, зөвлөмж боловсруулах; | ГБХНХЯ | I-II улирал |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| IV | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр | 43 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тогтолцооны загвар боловсруулах, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл өгөх, холбогдох судалгааг хийх; | ГБХНХЯ | I-II улирал |
| | | 44 | “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн систем (ом.inspection.gov.mn)-ийг шинэчлэн хөгжүүлж, үйл ажиллагааг жигдрүүлэх, "Төрийн цахим мэдээлэл солилцох систем"-д холбох ажлыг хийж гүйцэтгэх; | ГБХНХЯ | I-II улирал |
| | | 45 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэл мэдээллийн цахим системийг сурталчилан түгээх, | ГБХНХЯ | II-III улирал |
| | | 46 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлт харилцааны стратегийг тодорхойлох хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж, сурталчилгаа, урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаанд ашиглах; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 47 | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцоолол хийх;<br>*(сангийн урт хугацааны хэтийн төлөвийг тооцоолох)* | ГБХНХЯ | I-III улирал |
| | | 48 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн өнөөгийн нөхцөлд иж бүрэн үнэлгээ хийх; | ГБХНХЯ | I-III улирал |
| | | 49 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөний тандалт судалгаа хийх; | ХАБЭМТ | I-III улирал |
| | | 50 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох тандалт судалгаа хийх; | ХАБЭМТ | I-III улирал |
| | | 51 | Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогод өртөж буй шалтгаан нөхцөлийг судлах судалгааны ажлыг хийж, урьдчилан сэргийлэх цахим нөлөөллийн ажлыг зохион байгуулах; | ХАБЭМТ | II улирал |
| | | 52 | Мал, амьтны эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн лабораториуд, мал амьтны эмийн үйлдвэр болон эмийн санд ажиллагчдын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц | ХАБЭМТ | II улирал |

1119276397
5284708 СБА1473

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| IV | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр | | хордлогод өртөж буй шалтгаан нөхцөлд тандалт судалгаа хийж, дүгнэлт гарган холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | |
| | | 53 | Нийтийн аж ахуйн салбарын ажилтнууд мэргэжлээс шалтгаалсан өвчлөлд өртсөн эсэхэд судалгаа хийж, дүгнэлт гарган холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | ХАБЭМТ | II-IV улирал |
| | | 54 | Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудад мэргэжлээс шалтгаалсан өвчин үүссэн эсэхэд судалгаа хийж, дүгнэлт гарган холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | ХАБЭМТ | III-IV улирал |
| | | 55 | Уул уухайн салбарын топ 100 аж ахуйн нэгжийн ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны судалгаа хийж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох; | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 56 | Барилгын салбарын топ 100 аж ахуйн нэгжийн ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны судалгаа хийж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох; | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 57 | Төмөр замын салбар дахь мэргэжлээс шалтгаалсан өвчний тандан судалгаа, илрүүлэх ажил зохион байгуулж холбогдох журамд өөрчлөлт оруулах; | ХАБЭМТ | II-III улирал |
| | | 58 | 2022-2024 онуудад гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, ажил олгогч эзэд, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад зориулсан зөвлөмж боловсруулан гаргах, түгээх; | ХАБЭМТ | I-II улирал |
| | | 59 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ түүний зохистой байдалд үнэлгээ хийх судалгааны ажлыг зохион байгуулах; | ГБХНХЯ | II-III улирал |
| | | 60 | Орон нутгийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний судлан бүртгэх үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт хийн холбогдох  зөвлөмжийг боловсруулж, удирдлагаар хангах; | ГБХНХЯ | I-IV улирал |

---oOo---